



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/178/НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p> | <p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Цахим актив аудит ХХК-ны аудитор: Д. Балжинням Утас:99435309 Цахим хаяг: Dbaljinnyam573@gmail.com</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|-----------|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 9 |
| 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 10 |
| 3.1 Зөвлөмж | 10 |
| 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 12 |
| 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл | 12 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 809
танай _____ -ны № _____ -т

БУЯНТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Н.МАРТГУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд нийтийн бүжиг, концерт, дугуйлан зэрэг 56 үзвэр үйлчилгээ явуулж 2560 үзэгчид хамруулан 1,1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд урсгал төсвөөс 3.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, харьяа дээд шатны байгууллага болон Орон нутгийн хөгжлийн сан, хандив тусламжаар 56.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

8226050525

Бусад асуудал

Үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлтийг 82 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 6,231,662.82 | 3,245,884.73 |
| 33 | АВЛАГА | 1,998,093.62 | 1,548,084.73 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 781,119.73 | 331,110.84 |
| 335 | Бусад авлага | 1,216,973.89 | 1,216,973.89 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 1,211,973.89 | 1,211,973.89 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 5,000.00 | 5,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 4,233,569.20 | 1,697,800.00 |
| 351 | Түүхий эд материал | 150,000.00 | 150,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 150,000.00 | 150,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 4,083,569.20 | 1,547,800.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.00 | 12,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,000,000.00 | 1,055,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 0.00 | 480,000.00 |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 6,851,662.82 | 3,245,884.73 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,332,284,596.80 | 1,261,838,253.10 |
| 392 | Биет хөрөнгө | 1,301,134,596.80 | 1,231,063,253.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,217,861,377.30 | 1,217,861,377.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -109,586,174.00 | -203,267,818.16 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 135,084,140.00 | 139,675,140.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -35,653,551.19 | -64,859,000.91 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 81,797,878.00 | 140,543,878.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,644,122.11 | -37,480,586.41 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 15,230,000.00 | 15,230,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,739,142.00 | 2,739,142.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,643,485.20 | -2,328,270.72 |
| 39217 | Ном | 22,949,392.00 | 22,949,392.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 31,150,000.00 | 30,775,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,957,000.00 | 1,957,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,207,000.00 | -1,582,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 30,400,000.00 | 30,400,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,332,284,596.80 | 1,261,838,253.10 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,339,136,259.62 | 1,265,084,137.83 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,171,062.63 | 2,703,791.00 |
| 413 | Өглөг | 2,171,062.63 | 2,703,791.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 765,962.63 | 1,098,691.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,405,100.00 | 1,405,100.00 |
| 4136 | Бусад өглөг | 0.00 | 200,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 200,000.00 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,171,062.63 | 2,703,791.00 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,336,965,196.99 | 1,262,380,346.83 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 101,660,856.00 | 101,660,856.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 101,660,856.00 | 101,660,856.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,193,666,987.86 | 1,119,082,137.70 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,120,051,533.04 | 1,193,666,987.86 |

| | | | |
|----------|--|-------------------------|-------------------------|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 73,615,454.82 | -74,584,850.16 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 41,637,353.13 | 41,637,353.13 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,336,965,196.99 | 1,262,380,346.83 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,339,136,259.62 | 1,265,084,137.83 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 298,595,490.17 | 340,780,634.68 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 250,454,590.17 | 246,964,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 250,454,590.17 | 246,964,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 48,140,900.00 | 93,816,634.68 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,140,900.00 | 93,816,634.68 |
| 12 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | 120,879,154.66 | 59,591,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 120,879,154.66 | 59,591,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 112,618,440.00 | 59,591,000.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 419,474,644.83 | 400,371,634.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 350,899,207.87 | 474,956,484.84 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 326,698,607.37 | 468,356,019.74 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 173,754,399.02 | 206,154,470.11 |
| 210101 | Үндсэн цалин | 102,610,904.64 | 130,024,914.00 |
| 210102 | Нэмэгдэл | 45,277,990.29 | 65,149,695.00 |
| 210104 | Урамшуулал | 24,011,095.00 | 10,979,861.11 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 24,753,824.73 | 24,308,914.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,821,779.94 | 17,017,006.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,687,449.56 | 2,005,420.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 843,724.74 | 1,002,710.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,025,971.44 | 904,965.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,374,899.05 | 3,378,811.90 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 49,623,900.00 | 88,590,359.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,700,000.00 | 1,503,359.83 |
| 210302 | Түлш, халаалт | 46,536,400.00 | 87,087,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,286,630.80 | 4,562,631.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 487,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,216,430.80 | 440,279.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 341,152.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,720,200.00 | 202,700.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 0.00 | 3,091,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,067,300.00 | 4,520,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,867,300.00 | 2,704,000.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------------|------------------------------|
| 210604 | Урсгал засвар | 1,200,000.00 | 1,816,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,300,000.00 | 750,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,300,000.00 | 750,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,777,400.00 | 2,324,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,197,400.00 | 2,174,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 150,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,277,152.82 | 137,145,643.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,117,600.00 | 3,362,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 46,159,552.82 | 133,783,343.70 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 24,200,600.50 | 6,600,465.10 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,474,580.00 | 1,448,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,694,580.00 | 1,448,400.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 9,100.00 | 5,152,065.10 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,100.00 | 5,152,065.10 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 350,899,207.87 | 474,956,484.84 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>68,575,436.96</u> | <u>-74,584,850.16</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>68,575,436.96</u> | <u>-74,584,850.16</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 298,595,490.17 | 340,780,634.68 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 250,454,590.17 | 246,964,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 250,454,590.17 | 246,964,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 48,140,900.00 | 93,816,634.68 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,140,900.00 | 93,816,634.68 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>306,856,204.83</u> | <u>340,780,634.68</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 299,071,590.14 | 337,034,634.68 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 274,870,989.64 | 330,434,169.58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 171,960,631.19 | 204,557,211.64 |
| 210101 | Үндсэн цалин | 98,988,336.06 | 121,510,141.36 |
| 210102 | Нэмэгдэл | 50,305,797.52 | 68,495,575.08 |
| 210104 | Урамшуулал | 21,162,622.60 | 14,551,495.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,959,058.45 | 24,923,436.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,360,958.45 | 17,217,849.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,899,500.00 | 1,954,634.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 949,800.00 | 977,367.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 949,800.00 | 943,124.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,799,000.00 | 3,830,460.52 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 46,931,800.00 | 88,590,359.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,700,000.00 | 1,503,359.83 |

| | | | |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 210302 | Түлш, халаалт | 43,844,300.00 | 87,087,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,350,000.00 | 1,406,162.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 458,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,300,000.00 | 356,710.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 341,152.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,700,000.00 | 250,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,067,300.00 | 3,604,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,867,300.00 | 1,120,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 2,484,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,300,000.00 | 750,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,300,000.00 | 750,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,702,200.00 | 2,704,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,382,200.00 | 2,554,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 150,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,250,000.00 | 3,899,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,250,000.00 | 3,899,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 24,200,600.50 | 6,600,465.10 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,474,580.00 | 1,448,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,694,580.00 | 1,448,400.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 9,100.00 | 5,152,065.10 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,100.00 | 5,152,065.10 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2) | <u>299,071,590.14</u> | <u>337,034,634.68</u> |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>7,784,614.69</u> | <u>3,746,000.00</u> |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.00 | 3,746,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 3,746,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 3,746,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 0.00 | 3,746,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>0.00</u> | <u>-3,746,000.00</u> |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------------|---|
| C01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 101,660,856.00 | 41,637,353.13 | 1,193,666,987.86 | 1,336,965,196.99 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 101,660,856.00 | 41,637,353.13 | 1,193,666,987.86 | 1,336,965,196.99 |
| C10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 101,660,856.00 | 41,637,353.13 | 1,193,666,987.86 | 1,336,965,196.99 |
| C11 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 101,660,856.00 | 41,637,353.13 | 1,193,666,987.86 | 1,336,965,196.99 |

| | | | | | |
|-----|--|-----------------------|----------------------|-------------------------|-------------------------|
| C12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 101,660,856.00 | 41,637,353.13 | 1,193,666,987.86 | 1,336,965,196.99 |
| C19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -74,584,850.16 | -74,584,850.16 |
| C20 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 101,660,856.00 | 41,637,353.13 | 1,119,082,137.70 | 1,262,380,346.83 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|-----------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 12200 | ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 248,137,000.00 | 335,293,959.83 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 248,137,000.00 | 244,219,600.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 92,643,634.68 | 91,074,359.83 |
| 132003 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 92,643,634.68 | 91,074,359.83 |
| 12000 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | 77,065.32 | 334,700.00 |
| 120009 | Бусад орлого | 77,065.32 | |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 340,857,700.00 | 335,628,659.83 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 340,857,700.00 | 335,628,569.58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 339,409,300.00 | 334,180,169.58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 205,070,001.89 | 204,557,211.64 |
| 210101 | Үндсэн цалин | 121,510,141.36 | 121,510,141.36 |
| 210102 | Нэмэгдэл | 68,495,575.08 | 68,495,575.08 |
| 210104 | Урамшуулал | 15,064,285.45 | 14,551,495.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 24,923,436.11 | 24,923,436.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,217,849.73 | 17,217,849.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,954,634.16 | 1,954,634.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 977,367.10 | 977,367.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 943,124.60 | 943,124.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,830,460.52 | 3,830,460.52 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 93,187,000.00 | 88,590,359.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,960,000.00 | 1,503,359.83 |
| 210302 | Түлш, халаалт | 87,087,000.00 | 87,087,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 140,000.00 | 0.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,145,462.00 | 1,406,162.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 958,600.00 | 458,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 595,510.00 | 356,710.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 341,152.00 | 341,152.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 250,200.00 | 250,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,354,800.00 | 7,350,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,866,000.00 | 4,866,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,488,800.00 | 2,484,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 750,000.00 | 750,000.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 210702 | Дотоод албан томилолт | 750,000.00 | 750,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,079,600.00 | 2,704,000.00 |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | 2,929,600.00 | 2,554,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 150,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,899,000.00 | 3,899,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,899,000.00 | 3,899,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,448,400.00 | 1,448,400.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,448,400.00 | 1,448,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,448,400.00 | 1,448,400.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 340,857,700.00 | 335,628,569.58 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,380.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7,632.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинэ чанартай проекторыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн 3,091.0 мянган төгрөг,
- Тайлант оны эцэст төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг бүртгээгүй 2,651.0 мянган төгрөг,
- Хөрөнгийн элэгдэл тооцоогүй алдааг нөхөн бодож зардал бүртгэсэн 1,890.0 мянган төгрөгийн алдаа илэрлээ.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 2,748.0 мянган төгрөгийн 2 зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2,748.0 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Авлага, өглөг данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны санхүүгийн тайлангаар гэрэл цахилгааны төлбөр илүү шилжүүлсэн өмнөх оны авлага барагдуулаагүй 1,548.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх".16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" 16.5.3 -д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэнтэй

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага 2026 ондоо багтаан бүрэн барагдуулах, дараа тайлангаар дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.2. Орон нутгаас олгож буй тогтмол зардлын санхүүжилтийн зарцуулалттай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин, байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал болох аж ахуйн материал, морин хуурын засвар үйлчилгээний зардал санхүүжүүлсэн, төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн 1,200.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 211 дугаар тушаалын тавдугаар хавсралт “Урсгал зардлын ангилалын тайлбар”, 2103 -д” байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын тодорхойлолт” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн эдийн засгийн ангилал зөрчин зардал гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|------------|----------------|-----------------------------------|----------------|--------------------------|----------------|------------|----------------|--------------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн | 1 | 3,091.0 | | | 1 | 3,091.0 | 1 | 3,091.0 | - | - |
| Элэгдлийн зардал дутуу бүртгэсэн | 1 | 1,890.0 | | | 1 | 1,890.0 | 1 | 1,890.0 | | |
| Төвлөрүүлсэн мөнгө хөрөнгийг үлдэгдлээр бүртгэсэн | 1 | 2,651.0 | 1 | 2,651.0 | | | 1 | 2,651.0 | | |
| Дүн | 3 | 7,632.0 | 1 | 2,651.0 | 1 | 4,981.0 | 3 | 7,632.0 | | |

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдаа, зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|----------------|---------------|-----|-----------------|-----|----------|----------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант оны санхүүгийн тайлангаар гэрэл цахилгааны төлбөр илүү шилжүүлсэн өмнөх оны авлага барагдуулаагүй | 1 | 1,548.0 | | | | | 1 | 1,548.0 |
| Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин | 1 | 1,200.0 | | | | | 1 | 1,200.0 |
| Дүн | 2 | 2,748.0 | | | | | 2 | 2,748.0 |

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | 1 | | | |